



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3, 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.7, 29.1.10, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалаар баталсан журмыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Ш.Үнэнтөгс/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Энхбаатар/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Журам батлах тухай” А/41, А/48 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгосугай.



Д.ЗАНДАНБАТ

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ
АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ТУСГАЙ
ШАЛГАЛТЫН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн аудитын байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангах, төрийн аудитын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн иргэнийг удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт (цаашид “шалгалт” гэх)-аар сонгож авах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хамгийн сайн хангасан иргэнийг чадахуйн зарчимд үндэслэн сонгон шалгаруулж нэр дэвшүүлэхэд шалгалтын зорилго оршино.

1.3.Шалгалттай холбогдон гарах зардлыг Үндэсний аудитын газар хариуцна.

1.4.Шалгалтын комиссын ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батална.

Хоёр. Сул орон тоог зарлах

2.1.Төрийн аудитын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Үндэсний аудитын газрын Захиргаа, удирдлагын газар хариуцан сул орон тооны мэдээллийг тухай бүр цахим хуудсаар мэдээлэх бөгөөд шалгалтын зард сул орон тоо гарсан албан тушаалын нэр, ангилал, зэрэглэл, тавигдах шаардлага, бүртгэл хийх хэлбэр, хугацаа, байршил, бүрдүүлэх баримт бичиг, холбоо барих утасны дугаар зэргийг тусгана.

2.2.Төрийн аудитын байгууллагын удирдах албан тушаалын сул орон тоог дараах дарааллаар нөхнө:

2.2.1.шатлан дэвшүүлэх зарчмын дагуу төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас;

2.2.2.бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас;

2.2.3.удирдах, гүйцэтгэх албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс;

2.3.төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог дараах дарааллаар нөхнө:

2.3.1.шатлан дэвшүүлэх зарчмын дагуу Төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас;

2.3.2.төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа иргэдээс.

2.4.Захиргаа, удирдлагын газар энэхүү журмын 2.2, 2.3-т заасан дарааллын дагуу сул орон тоог нөхөх зарыг шалгалтын бүртгэл эхлэхээс ажлын 10 өдрийн өмнө цахим хуудсаар зарлана.

Гурав. Шалгалт өгөх болзол

3.1.Дараах болзлыг хангасан албан хаагч, иргэн шалгалтад бүртгүүлнэ:

3.1.1.Монгол Улсын иргэн байх;

3.1.2.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;

3.1.3.Сүүлийн 12 сарын дотор ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх;

3.1.4.Төрийн жинхэнэ албан хаагч эсхүл төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн иргэн байх;

3.1.5.Тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Дөрөв. Шалгалтын бүртгэл

4.1.Шалгалтын бүртгэлийг ажлын 1 өдрийн хугацаанд явуулах бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

4.1.1.төрийн албан хаагчийн анкет;

4.1.2.шалгалтад бүртгүүлэх тухай бичгээр гаргасан хүсэлт; /батлагдсан маягтын дагуу/

4.1.3.иргэний үнэмлэхийн хуулбар, эх хувийн хамт;

4.1.4.боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт /хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/;

4.1.5.мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт;

4.1.6.хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, цахим, эх хувийн хамт;

4.1.7.төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэйг нотлох баримт бичиг;

4.1.8.төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд сүүлийн 12 сарын хугацаанд ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүй талаарх тодорхойлолт;

4.1.9.төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй иргэнд энэхүү журмын 4.1.8 дахь заалт хамаарахгүй.

4.1.10.“4 х 6”-гийн хэмжээний цээж зураг;

4.1.11.Төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа албан хаагч шатлан дэвшиж ажиллахаар тусгай шалгалт өгөх хүсэлт гаргасан бол холбогдох материалыг хувийн хэргээс хуулбарлан авч өөрөө бүртгүүлнэ.

4.2.Шалгалтад орохыг хүсэгчийн материалыг цахимаар хүлээн авч бүртгэнэ.

4.3.Энэ журмын 3.1-д заасан болзлыг хангаж, 4.1-д заасан холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн төрийн жинхэнэ албан хаагч, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэнийг шалгалтад оролцуулахаар бүртгэх, эсэх асуудлыг шалгалтын комисс хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд болзол хангаагүй бол албан хаагч, иргэнд шалтгааныг мэдэгдэнэ.

Тав. Шалгалтын агуулга, хугацаа, хэлбэр, үнэлгээ

5.1.Шалгалтын хэлбэр, агуулга:

5.1.1.хууль, эрх зүйн мэдлэг сорих шалгалт нь Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт болон бусад хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан тест;

5.1.2.ур чадварын шалгалт нь тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадварыг илэрхийлэх даалгавар;

5.1.3.ярилцлагын шалгалт нь тодорхой бэлтгэгдсэн асуулт байна.

5.2.Шалгалтын үргэлжлэх хугацаа, үнэлгээ, шалгуур үзүүлэлт;

5.2.1.хууль, эрх зүйн мэдлэг сорих шалгалтыг нийт 60 асуулттай, нэг зөв хариултыг 0,5 оноогоор дүгнэх бөгөөд нийт 30 хүртэл оноогоор үнэлнэ. Тус шалгалтын нэг асуултад хариулах хугацаа 1 минут буюу нийт үргэлжлэх хугацаа 60 минут байна.

5.2.2.ур чадварын шалгалт нь удирдах болон гүйцэтгэх албан тушаалын хувьд ялгаатай бөгөөд тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан ур чадваруудыг шаардсан даалгаврыг гүйцэтгүүлэн дараах шалгуураар үнэлнэ.

5.2.2.1.удирдах албан тушаалтны ур чадварын шалгалтыг удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, илтгэх ур чадваруудыг тус бүр дүгнэн, нийт 50 хүртэл оноогоор үнэлнэ.

5.2.2.2.гүйцэтгэх албан тушаалтны ур чадварын шалгалтыг дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, илтгэх ур чадваруудыг тус бүр дүгнэн, нийт 50 хүртэл оноогоор үнэлнэ.

5.2.3.ур чадварын шалгалтын үргэлжлэх хугацаа нь шалгуулагч даалгаврыг 30 минутад гүйцэтгэн, 10 минутад багтаан танилцуулна.

5.2.4.ярилцлагын шалгалт нь 2 асуулттай, 10 минут үргэлжлэх бөгөөд 20 хүртэл оноогоор үнэлнэ.

5.2.5.ярилцлагын шалгалтыг шалгуулагчийн сонсох чадвар, өөрийгөө илэрхийлэх чадвар, асуудлыг хэрхэн тайлбарлан хариулж байгаа байдал гэсэн шалгууруудаар үнэлнэ.

5.3.Шалгуулагч нь нийт шалгалтын нийлбэр дүнгээр 60 буюу түүнээс дээш оноо авсан тохиолдолд тэнцсэнд тооцно.

5.4.Төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаад шатлан дэвших шалгалт өгсөн шалгуулагч нь нийт шалгалтын нийлбэр дүнгээр 42 буюу түүнээс дээш оноо авсан тохиолдолд тэнцсэнд тооцно.

5.5.Шалгалтын хууль, эрх зүйн мэдлэг сорих тест, ур чадварын шалгалтын даалгавар, ярилцлагын шалгалтын асуултын санг бүрдүүлэх, баяжуулах ажлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар, Захиргаа, удирдлагын газар, шалгалтын материалын сангийн нууцлал, хадгалалт хамгаалалт, шалгалт авах техникийн бэлэн байдлыг хангах ажлыг Мэдээллийн технологийн төв тус тус хариуцна.

5.6.Шалгалтыг танхимаар эсхүл цахимаар зохион байгуулахыг комисс шийдвэрлэж шалгалтын зард тодорхой заана.

5.7.Удирдах, гүйцэтгэх албан тушаал, албан тушаалын ангиллаас хамаарч энэ журмын 5.1-д заасан шалгалтын агуулга ялгаатай байж болно.

5.8.Удирдах, гүйцэтгэх албан тушаалд төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх зарчмын дагуу шалгалт өгч байгаа бол энэ журмын 5.1.2, 5.1.3-т заасан шалгалтыг авна.

5.9.Мэргэшсэн нягтлан бодогчийн болон мэргэшсэн санхүүгийн шинжээчийн олон улсын эрхтэй эсхүл төрийн аудитын байгууллагын зорилго чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байгаа Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэх өндөр ур чадвартай иргэнийг Төрийн аудитын байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалд нэр дэвшсэн тохиолдолд энэ журмын 2.2, 2.3, 4.1.7, 8.1 дэх заалт хамаарахгүй.

5.10.Төрийн аудитын байгууллагад ажиллаж байгаад шатлан дэвшихээр шалгалт өгсөн албан хаагчийн нийт оноо тэнцсэн тохиолдолд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзана.

5.11.Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс энэхүү журам батлагдах хүртэл хугацаанд шинээр томилогдсон болон ажил, албан тушаалын чиг үүрэг нь өөрчлөгдөж шатлан дэвшсэн албан хаагчдыг нэмэлт зохицуулалтаар тусгай шалгалтад хамруулах бөгөөд уг шалгалтыг зохион байгуулах арга, хэлбэр, хугацааг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар тодорхойлно.

Зургаа. Нэр дэвшүүлэх

6.1.Комисс шалгалт дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан шалгалтын дүнг гаргаж хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар

нэр дэвшүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна. Шалгалтын тайланд шалгалтын явц, оролцогчдын үнэлгээний талаар дэлгэрэнгүй тусгана.

6.2.Монгол Улсын Ерөнхий аудитор удирдах албан тушаалд нэр дэвшигчийг томилохоос хуульд заасан үндэслэлээр нэг удаа татгалзаж болно. Энэ тохиолдолд татгалзсан үндэслэлийг шалгалтын комисс ажлын 14 хоногийн дотор хянаж, хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл, тухайн шалгалтад оролцогчдоос онооны дарааллыг баримтлан дахин нэр дэвшүүлнэ.

Долоо. Хариуцлага

7.1.Тухайн албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагыг хангаагүй, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, худал мэдүүлсэн бол тухайн иргэн, албан хаагчийн шалгалтыг хүчингүйд тооцно.

7.2.Хууль, эрх зүйн мэдлэг сорих шалгалт өгч байх хугацаанд шалгалтын системээс өөр цахим сүлжээ ашиглаж мэдээлэл хайсан, шалгалтыг аливаа хэлбэрээр хуурамчаар өгөхийг завдсан шалгуулагчийн шалгалтыг хүчингүйд тооцно.

7.3.шалгалтыг хуурамчаар өгсөн нь нотлогдвол шалгалтыг хүчингүй болгож, томилогдсон албан тушаалаас чөлөөлж, хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

Найм. Бусад зүйл

8.1.Төрийн жинхэнэ албан хаагчийг шатлан дэвшүүлэхдээ албан тушаалын ангилал алгасуулахыг хориглоно.

8.2.Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасны дагуу албан тушаалын тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн жинхэнэ албан хаагчийг энэ журмыг баримтлан шалгалт авна.

8.3.Журмын 4.3-т мэдэгдлийг хүлээн авсан иргэн, албан хаагч ажлын 1 өдрийн дотор Шалгалтын комисст гомдол гаргаж болно.

--- оОо ---